



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 1/274

Мандалговь

Тооллогын комисс томилох тухай

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.5, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралт, Батлан хамгаалахын сайдын 2019 оны н/19 дүгээр тушаалаар батлагдсан “Монгол Улсын батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”-ын 2.1.5 заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Цэргийн штабын 2022 оны жилийн эцсийн дайчилгааны нууцын тооллого явуулах комиссийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Ш.Гансүх (Цэргийн штабын дарга, дэд хурандаа)
Гишүүдэд: Ц.Баттулга (Цэргийн штабын ОНХ, сургалтын офицер дэд хурандаа)
Н.Сүхбаатар (СТСХ-ийн төсвийн ахлах мэргэжилтэн, Улсын дайчилгааны мэргэжилтэн)

2. Цэргийн штабын архив, албан хэрэг хөтлөлт, дайчилгааны нууцын баримт бичиг болон бусад нууц тээгчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд 2022 оны 12 дугаар сарын 05-наас 07-ний хооронд нэг бүрчлэн тооллого хийж, цаашид авах арга хэмжээний талаарх санал, дүгнэлтийг тусгаж акт үйлдэн холбогдох байгууллагад нь хүргүүлэхийг комиссын дарга (дэд хурандаа Ш.Гансүх)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

48.2150594